

“РЕМИКОН” ХК-ИЙН
“ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ”-ИЙН
ХУРЛЫН ШИЙДВЭР

2017 оны 03-р сарын 17-ны өдөр

Дугаар 17/1/6

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай

“Ремикон” ХК-ийн 2017 оны 03-р сарын 17-ны өдрийн “Төлөөлөн Удирдах Зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Ремикон” ХК-ийн ээлжит “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ыг 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн *Баасан гаригт* 11.00 цагт “Хера Индастриал парк”-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд санал авах хуудас болон хурлын материалтай “Гаули” ХХК брокер дилерийн компани дээр 2017 оны 03-р сарын 22-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцсугай.
4. Бичгээр санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 04 дүгээр сарын 25-ны 17:00 цаг хүртэл брокер дилерийн компанид буюу “Гаули” ХХК-ийн байран дээр авахаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай “Хувьцаа Эзэмшигч”-дэд зарлах өдрийг 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосугай.
6. “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ыг зохион байгуулах комиссын даргаар Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Эрдэнэбаярыг томилсугай.
7. “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ын даргаар Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Эрдэнэбаярыг томилсугай.
8. “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ын тооллогын комиссын даргаар Б.Алтанцэцэгийг, гишүүнээр Т.Одмаа нарыг томилсугай.

9. “Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал”-аар хэлэлцэх асуудлын жагсаалтыг *Хавсралт №1*–ээр баталсугай.
10. “Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал”-ын талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд мэдээллэх зарын загварыг *Хавсралт №2*–оор баталсугай.
11. “Ремикон” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал-д санал авах хуудсыг *Хавсралт №3*-аар баталсугай.
12. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг *Хавсралт №4*–оор баталсугай.



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн

ТУЗ гишүүн(Н.Золбоо)

ТУЗ гишүүн(Д.Алтанхуяг)

ТУЗ гишүүн(Н.Батгэрэл)

ТУЗ гишүүн(С.Баянмөнх)

ТУЗ гишүүн(Ч.Мөнгөнсүх)

ТУЗ гишүүн(Ц.Эрдэнэбаяр)

ТУЗ гишүүн(Г.Батхуяг)

ТУЗ гишүүн(Б.Батсайхан)

ТУЗ гишүүн(Х.Ганхуяг)

ТУЗ дарга(Э.Мөнхсайхан)

2017.03.17 өдрийн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ
ХУРАЛДАХАД ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

Хэлэлцэх асуудал:

1. Ремикон ХК-ийн 2016 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах,
2. Ремикон ХК-ийн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах,
3. Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг томилох,
4. Ремикон ХК-иас 2016 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар танилцуулах,
5. Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулах,

**РЕМИКОН ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

1. Ремикон ХК-ийн 2016 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах,
2. Ремикон ХК-ийн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөтэй танилцах,
3. Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн эрхийг сунгах,
4. Ремикон ХК-иас 2016 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар танилцуулах,
5. Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулах,

Ремикон ХК-д хувьцаа эзэмшигч ээлжит хурлын материалтай Гаүли ХХК брокер дилерийн компанийн байранд 2017 оны 03-р сарын 22-ний өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцана уу.

РЕМИКОН ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
Утас: 88116894, 88065253, E-mail: info@remicon.mn



ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ

- 1.Ремикон ХК-ийн 2016 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
2. Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн эрхийг сунгах шийдвэр,
- 3.Ремикон ХК-иас 2016 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол,
- 4.Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааны тайлан



**“РЕМИКОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ
АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Хэлэлцэх асуудлууд

№	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан
1.	2015 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах		
2.	Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн эрхийг сунган томилох		

Жич: Хэрэв та хуралд биечлэн оролцох боломжгүй бол өөрийн итгэмжлэлт төлөөлөгчийг оролцуулах буюу 2017 оны 04 сарын 25 -ны дотор бөглөсөн саналын хуудсаа харьяа брокер диллерийн компанид хүргүүлж саналаа өгч болно.

Брокер...../

/

Хувь нийлүүлэгч...../

/

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

1. Саналын хуудсыг хүчинтэйд тооцов.
2. Саналын хуудсыг хуудсыг хүчингүйд тооцов.

Шалтгаан.....

Тооллогын комиссын дарга.....